

ХЯТАД БА ДАЛАЙ ЛАМЫН ХЭЛЭЛЦЭЭ

*Ш.Догмийчойдон**

Өнгөрсөн 2002 оны 9-р сард Далай ламын Америк дахь тусгай элч Гяри Лодойжалцан, Европ дахь тусгай элч Галсанжалцан нарын төлөөлөгчид БНХАУ-д айлчилсан нь 1993 оноос хойш тасраад байсан Далай ламын Засгийн газар болон БНХАУ-ын харилцаанд нэгэн чухал алхам болов.

БНХАУ байгуулагдсанаас хойш Хятадын Төв Засгийн газар, Төвдийн орон нутгийн Засгийн газрын хооронд анхны 17 зүйлт хэлэлцээрт 1951 оны 5-р сарын 23-нд Бээжин хотноо гарын үсэг зуржээ.¹ 1959 онд Төвдөд дэгдсэн үймээн самуун, зөрчил сөргөлдөөний улмаас Далай лам тойрон хүрээлэгч, шүтлэгтнүүдийнхээ хамт нутгаасаа дүрвэн гарч Энэтхэгийн Дармасалад цагаачлан суурьшсан юм.

Далай лам түүний засгийн газар Дармасалад цагаачлан суурьших болсноос хойш хоёр тал янз бүрийн шатанд хэлэлцээ хийхийг эрмэлзэж байв. 1980 оны эхээр Хятадын удирдагч Дэн Сяопин “Төвд бие даасан, тусгаар тогтносон улс биш” гээд Далай ламтай хэлэлцээ хийхэд бэлэн байгаагаа мэдэгдэж байв.² Түүний хойно 1988 онд Далай лам Францын Страссбург хотноо Европын Парламентэд хэлсэн үгэндээ Төвдийг тусгаар тогтноулах гэсэн шаардлагаасаа татгалзаж байгаагаа мэдэгдээд Төвдөд жинхэнэ утгаар нь “өөртөө засах эрх” олгох хэрэгтэйг дурджээ.³ Тэр үеэс эхлэн Дармасалад цагаачлан суурьшсан төвдүүд “Цөллөгөн дэх” Төвдийн засгийн газар хэмээхийг байгуулж үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн юм. Хоёр тал янз бүрийн шатанд олон удаа харилцан хэлэлцээ хийх талаар ярилцаж байсан боловч ямар нэгэн тохиролцоонд хүрч чадалгүй байсаар 90-ээд оны дунд үеэс харилцаа бүрэн зогсжээ.

БНХАУ Далай ламтай хэлэлцээ хийхийг нэлээд улс орон, тухайлбал АНУ болон Европын Холбооны улсууд дэмжиж байгаа бөгөөд бүр Европын Парламент 2000 оны 7-р сарын 6-нд БНХАУ, Далай ламын хооронд хэлэлцээ хийж, батлан хамгаалах, гадаад бодлогоос бусад бүх салбарт Төвдийн ард түмэнд өөртөө засах статус олгохын төлөө бүх алхам хийхийг уриалж, 2003 оны 7-р сарын 6 хүртэлх 3 жилийн хугацаанд хоёр тал ямар нэг тохиролцоонд хүрэхгүй бол “Цөллөгөн дэх” Төвдийн засгийн газрыг төвдийн ард түмний хууль ёсны төлөөлөгч гэж үзэхээ зарласан юм.⁴ Мөн АНУ-ын Ерөнхийлөгч

*Ш.Догмийчойдон - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан

Ж.Буш 2003 оны 5-р сарын 8-нд Конгресст хийсэн мэдээлэлдээ Хятад, Далай ламын хооронд харилцаа сэргэх хандлага ажиглагдаж байгааг тэмдэглэн дэмжиж буйгаа илэрхийлжээ.⁵

2002 оны 9-р сард Далай ламын төлөөлөгчид БНХАУ-ын нийслэл Бээжин болон Чэнду, Шанхай хот, ТӨЗО-ы төв Лхас, Ньингчи, Шигазе зэрэг газруудад очиж нөхцөл байдалтай нь танилцаж, зарим удирдлагуудтай нь уулзаж, харилцан ярилцаж, санал солилцжээ. Айлчлалын гол зорилго нь харилцан итгэлцлийг бэхжүүлэх явдал байсан бөгөөд энэ тухай төлөөлөгчдийн тэргүүн Гяри Подойжалцан айлчлалын дараа гаргасан албан мэдээндээ “Бидний айлчлалын зорилго нэгдүгээрт, Хятадын удирдагчтай харилцаагаа дахин сэргээж цаашид гүнзгийрүүлэн хэлэлцээ хийх таатай орчин бүрдүүлэх, хоёрдугаарт, Төвдийн бэрхшээлийг арилгах арга замын тухай саналаа Хятадын удирдагчдад танилцуулж харилцан итгэлцлийг нэмэгдүүлэх явдал байв. Өнгөрсөн олон жилийн хугацаанд Дээрхийн гэгээнтэн Хятадын удирдлагатай харилцаагаа сэргээх арга зам хайж байсан бөгөөд Хятадын Засгийн газраас харилцааны үндсийг тавьж, манай төлөөлөгчдийг айлчлахыг урьсанд баяртай хүлээн авсан юм” хэмээн дурдсан юм.⁶

Төлөөлөгчид ТӨЗО-ы нийслэл Лхасад очиж Будалин ордон болон зарим сүм хийдийг үзэж сонирхож, Төвдийн хөгжил бүтээн байгуулалттай танилцан, эдийн засгийг хөгжүүлэх Хятадын бодлогыг дэмжихийн хамт төвдийн өвөрмөц шашин, соёл, хэл бичиг болон хүрээлэн буй орчныг хамгаалах талаар анхаарал тавихыг хүссэн байна.

Айлчлалын үеэр Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их Хурал, ХКН-ын Төв Хорооны Нэгдмэл фронтын хэлтсийн дарга ноён Ван Жаого, Үндэсний хэрэг эрхлэх газрын дарга, Нэгдмэл фронтын хэлтсийн орлогч дарга ноён Лидэ жү, БХАТИХ-ын Байнгын Хорооны орлогч дарга Агваанжигмэд, ТӨЗО-ы АТХ-ын дарга, ӨЗО-ы КН-ын орлогч дарга Ради, ТӨЗО-ы Ардын Засгийн газрын гишүүн Лэгцог, ТӨЗО-ы Нэгдмэл фронтын дарга Самдүв, Сычуань мужийн Ардын Төлөөлөгчдийн Хурлын орлогч дарга Анприн зэрэг албаны хүмүүстэй уулзаж, харилцан ярилцаж санал бодлоо чөлөөтэй солилцжээ.

2003 оны 5-р сард Далай ламын төлөөлөгчид БНХАУ-д хэлэлцээ хийхээр дахин ирсэн боловч БНХАУ-ын шинэ ерөнхийлөгч Ху Зиньгао Монгол, ОХУ, Казакстан зэрэг улсад анхны айлчлалаа хийх гэж байгаа болон SARS-ын хямралаас болж хойшлуулжээ.⁷

Үүний дараа 2003 оны 6-р сарын 8-14-нд Далай ламын төлөөлөгчид БНХАУ-д дахин айлчилж албаны хүмүүстэй уулзаж ярилцжээ. Энэ удаагийн яриа хэлэлцээний талаар албан ёсны мэдээлэл гараагүй ч хоёр тал нэлээд олон зүйл дээр санал зөрөлдсөн тухай хэвлэлүүд мэдээлсэн юм.⁸ Айлчлалын үеэр төлөөлөгчид Бээжин, Зяньсу, Жэзян, Юньнань зэрэг газруудыг үзэж сонирхсон байна.

Түүний хойно 2003 оны 6-р сарын 4-нд Далай лам Данийн нийслэл Копенгаген хотноо хийсэн мэдэгдэлдээ БНХАУ-тай өөрийн төлөөлөгчдийн хийсэн хэлэлцээнд сэтгэл хангалуун байна гээд хэлэлцээний хамгийн гол зорилго нь хоёр тал харилцан итгэлцлийг бий болгох явдал хэмээн онцлон тэмдэглэж энэ бол сайн эхлэл юм. Бид нэг Хятад гэсэн зарчмыг баримтлах болно хэмээсэн байна.⁹

Хэдий тийм боловч Далай лам АНУ, Япон болон Европын зарим орнуудаар айлчилсанд тухай бүрд нь БНХАУ-ын Засгийн газар эсэргүүцлээ илэрхийлж байв. Далай ламын эдгээр айлчлалын зорилго цэвэр шашны шинжтэй гэх боловч өрнөдийн зарим ажиглагчдын үзэж байгаагаар Хятадтай хийсэн хэлэлцээний үеэр тохиролцоонд хүрч чадаагүй асуудалдаа эдгээр орны зүгээс дэмжлэг авах зорилготой ажээ.

Энэ бүхнээс үзэхэд Хятад улс болон Далай ламын харилцаа нь урьдын байдлыг бодвол дээшилж, удаа дараа төлөөлөгчид айлчилж, харилцан санал бодлоо солилцож, хэлэлцээ хийх хэмжээнд хүрээд байгаа боловч хүссэн хэмжээний үр дүн өгөөгүй байна. Хэрэв хоёр тал хэлэлцээ хийж Далай лам болон Дармасалад байгаа Засгийн газар Төвддөө будаж очихоор болбол “Цөллөгөн дэх” засгийн газрыг тарааж, шилжилтийн үеийн орон нутгийн засгийн газар байгуулж, 2 жилийн дотор ард түмний сонгуулиар шинэ засгийн газар байгуулах бөгөөд Далай лам тэр засгийн газарт засаг захиргааны бүх эрхээ шилжүүлэх тухай Дармасалад байгаа Далай ламын засгийн газрын “Үндсэн хууль”-д заасан байдаг ажээ.¹⁰

Төвдийн асуудлаар БНХАУ-ын баримталж буй бодлогыг ОХУ бүрэн дэмжиж байгаа бөгөөд энэ оны 9-р сард Далай ламыг Халимагт айлчлахад виз олгоогүй билээ. Энэ тухай ОХУ-ын Ерөнхий сайд М.Касьянов БНХАУ-д энэ оны 9-р сард албан ёсны айлчлал хийхдээ “Манай Гадаад хэргийн яам Хятадтай харилцаагаа муутгахгүйн тулд Далай ламыг Орос руу нэвтрүүлэхгүй гэсэн. Үүнийгээ ил тод зарлаж байгаа” хэмээн мэдэгдсэн юм.¹¹

Мөн 2003 оны 6-р сарын сүүлчээр Энэтхэгийн Ерөнхий сайд А.Б.Важпай БНХАУ-д хийсэн албан ёсны айлчлалын үеэрээ Төвдийг

БНХАУ-ын салшгүй хэсэг болохыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн билээ.¹²

Манай улсын хувьд хүн амын 70 шахам хувь буддын шашин шүтдэг бөгөөд сүсэгтэн олны хүсэлт, шарын шашны тэргүүний хувьд шашны шугамаар Далай лам Монгол Улсад нийт 6 удаа айлчилжээ. Айлчлал бүр БНХАУ-ын эсэргүүцэлтэй тулгарч байв. Сүүлийн буюу 2002 оны айлчлалын үед БНХАУ төмөр замын боомтоо хааж байсныг олон улсын мэдээллийн хэрэгслэлүүд бүгд Далай ламын айлчлалтай холбон тайлбарласан юм.¹³

Ер нь Далай ламын айлчлал нь Хятад, Монголын найрсаг харилцаатай холбоотой нэгэн эмзэг асуудал болоод байна. Энэ тухай БНХАУ-аас тус улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Хуан Жякуй “Монголд Далай лам айлчлахад Хятадын ард түмэн, үндэстнүүдийн санаа сэтгэлд хохирол учруулж, Хятад улсын бүрэн эрх, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал болон үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал юм” хэмээн “Зууны мэдээ” сонинд өгсөн ярилцлагадаа онцлон тэмдэглэсэн юм.¹⁴

Эцэст нь анхаарал татах нэг асуудал бол БНХАУ ХҮ Далай ламтай ямар нэг тохиролцоонд хүрэлгүй өнгөрвөл яах вэ? гэсэн асуудал юм. Энэ тухай Далай лам “Хэрэв би Төвдөд буцаж очиж чадалгүй нас эцэслэвэл дараагийн Далай лам БНХАУ-ын ТӨЗО-оос бус гаднаас тодрох болно. Гадаадад суугаа төвдүүд түүнийг миний залгамжлагчаар сонгох болно. Хойд дүрийг тодруулахын жинхэнэ зорилго нь өмнөх Далай ламын санаачилж, гүйцэлдүүлж чадаагүй үйл хэргийг үргэлжлүүлэн явуулахад оршдог юм.” хэмээн нэгэн ярилцлагадаа хэлсэн байдаг.¹⁵ Гэвч өмнө нь XI Ванчин Богдыг тодруулж байсан шиг нөхцөл байдал үүсч болох юм. 1995 онд Далай лам 6 настай хүүг X Ванчин Богдын хойд дүрээр тодруулсан боловч Хятадын Засгийн газар хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд мөн ондоо өөр нэгэн 6 настай хүүг XI Ванчин Богдоор тодруулсан байдаг. Түүн шиг гадаадад суугаа төвдүүд Далай ламын хойд дүрийг тодруулсан ч Хятадын Засгийн газар ТӨЗО-ноос өөр нэг Далай ламыг тодруулж болох юм. Далай ламын ярьснаар БНХАУ-ын ТӨЗО-ы дотроос түүний хойд дүр тодрохгүй л юм бол хаа холын Африк тивд тодрохгүй нь ойлгомжтой бөгөөд буддын шашинт сүсэгтэн олон зонхилох газар л тодрох учиртай.

Энэ бүхнийг нуршихын учир гэвэл Далай ламын институт 500 гаруй жилийн түүхтэй бөгөөд нийт 14 Далай лам тодруулснаас

дөрөвдүгээр Далай лам Ёндонжамц (1589-1616) нь монгол хүн, Түмэдийн Алтан хааны угсааны хүн байсан юм.

Төвдийн асуудлаар манай улс БНХАУ-ын албан ёсны байр суурийг дэмждэг бөгөөд монголын сүсэгтэн олон Далай ламыг шашны тэргүүн гэдэг утгаар сүсэглэн залбирч байдаг билээ. Түүх давтагдахгүй байхын аргагүй бөгөөд үнэхээр дараагийн Далай лам Монголоос тодорвол ...?

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. В.А.Богословский. “БНХАУын Төвд муж”. УБ. 1982, х.38
2. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu270503tib-2.htm>
3. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu270503tib-2.htm>
4. <http://www2.europarl.eu.int/omk/sipade2?PUBREF=-//EP//TEXT+PRESS+DN-20000706-2+0+DOC+XML+V0//EN&LEVEL=2&NAV=S#SECTION1>
5. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu270503tib-1.htm>
6. <http://www.tibet.net/tibflash/>
7. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu270503tib-1.htm>
8. <http://www.tibetinfo.net/news-updates/Tibetan/nu120603tib-1.htm>
9. “Өдрийн сонин”. 2003.06.06
10. <http://www.tibet.net/tgie/tib/>
11. “Зууны мэдээ”. 2003.10.03
12. “Зууны мэдээ”. 2003.06.26, “Өдрийн сонин”. 2003.06.26
13. Б.Содон. “Далай лам: шашин, улс төр”. “Стратеги судлал” сэтгүүл. 2002. №2, х.205
14. “Зууны мэдээ”. 2003.10.09
15. Б.Содон. “Далай лам: шашин, улс төр”. “Стратеги судлал” сэтгүүл. 2002. №2, х.202